

## Агуулга

- Оршил, түүхэн замнал
- Аж үйлдвэр
  - Уул уурхай олборлох салбар
  - Боловсруулах аж үйлдвэр
  - Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж
- Барилга
- Тээвэр холбоо, дэд бүтэц
- Бүртгэлтэй аж ахуй нэгж
- Дотоодын нийт бүтээгдэхүүн
  - аж үйлдвэр, барилгын салбарын дотоодын нийт бүтээгдэхүүн
  - Аймгийн 1 хүнд ноогдох дотоодын нийт бүтээгдэхүүн
- Дүгнэлт

## **Оршил**

Энэхүү танилцуулга нь Дундговь аймгийн аж үйлдвэр үйлчилгээний салбар 2018 онд хэрхэн өсч хөгжсөн аймаг орон нутгийн эдийн засгийн хөгжилд ямар хувь нэмэр оруулсан, үйлдвэр, барилгын салбарын статистик үзүүлэлтүүдийг нэгтгэн бодлого боловсруулагчдад хүргэх зорилготой юм.

Аж үйлдвэрийн салбар нь уул уурхай олборлох салбар, боловсруулах аж үйлдвэр мөн цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж гэсэн дэд бүлгүүдээс бүрддэг ба танилцуулгад орсон тоо мэдээллийн эх сурвалж нь аж үйлдвэрийн сар, улирал, жилийн мэдээ тайлан юм.

## **Ойлголт, тодорхойлолт**

Аж үйлдвэрийн салбарын үйл ажиллагааг аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагчид, зардал, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээ, борлуулалт, үндсэн хөрөнгө болон санхүүгийн үндсэн үзүүлэлтүүдээр илэрхийлж, аж ахуйн нэгжийн сар, жилийн тайлан, тооллого судалгааны үр дүнгийн тоон мэдээллийг ашиглан тэдгээрийг нэгтгэн гаргадаг.

**Бүтээгдэхүүн** гэж үйлдвэрлэлийн үр дүнд бий болсон бараа, үйлчилгээг хэлнэ.

**Үйлдвэрлэл нь** тухайн аж ахуйн нэгжийн зах зээлд болон өөрийн эцсийн хэрэглээнд зориулж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээс бүрдэнэ.

**Гол нэр төрлийн бүтээгдэхүүн** гэж тайлант хугацаанд үйлдвэрлэсэн салбарын үйлдвэрлэлийг төлөөлөхүйц бүтээгдэхүүнийг хэлнэ.

**Борлуулалт нь** Тайлангийн хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил үйлчилгээ, бүтээгдэхүүний борлуулалтыг хэлнэ.

Хэд хэдэн төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, ажил үйлчилгээ эрхэлдэг аж ахуй нэгжийг өндөр хувийн жинтэй бүтээгдэхүүн, ажил үйлчилгээгээр нь холбогдох салбарт хамруулна.

Цахилгаан станц, нүүрсний уурхайн мэдээг үндэслэн цахилгаан, дулаан эрчим хүч, нүүрсний тэнцлийг жилд нэг удаа нэгтгэн гаргадаг.

Үйлдвэрлэсэн, импортлосон цахилгаан эрчим хүч, нүүрсний хэмжээ, цахилгаан станцын дотоод хэрэглээ, түгээлтийн болон шугамын алдагдал, хуваарилалтыг эдийн засгийн үйл ажиллагааны голлох салбараар ангилж, биет хэмжээгээр тэнцэлд тусгаж байна.

## **Салбарын түүхэн замнал**

Аймгийн хөгжлийн эхний 50 жил буюу социализмын үеийн хөгжлийн жилүүдэд олсон томоохон амжилтуудын нэг нь орчин үеийн аж үйлдвэрийн салбар үүсч хөгжсөн явдал юм. Тус аймагт 1942 онд нийтийн хоол боловсруулах гуанз байгуулагдсанаар хүнсний болон аж үйлдвэрийн суурь тавигджээ. Улмаар энэ нь өргөжиж 1974 он гэхэд 4 тасагтай 50 гаруй ажилтантай болж жилдээ 1.4 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 6 сая төгрөгийн борлуулалт хийж байв. 1986 онд талх, нарийн боов, гоймон, архи, ундаа, сүү боловсруулж үйлдвэрлэх үндсэн 6 цехтэй шинэ үйлдвэр ашиглалтанд орсон байна.

Үүнээс хойш 1949 онд аймгийн үйлдвэр хоршооллын артельд 1 мужаантай мод боловсруулах үйлдвэрийн суурь , 1948 онд гар ажиллагаатай хэвлэх үйлдвэр мөн 1961 оны 10 сарын 19-нд Эрдэнэдалай сумын нутаг Элэгний говийн нүүрсний ордод түшиглэн Цагаан овоогийн нүүрсний уурхайг 19 ажилтан, 5 гэр, 2 машинтай ашиглалтанд оруулснаар уул уурхай, олборлох салбарын суурь тус тус тавигдсанаар тус аймагт аж үйлдвэрийн салбар хөгжиж байсан байна. 1990 оны нийгэм эдийн засгийн өөрчлөлтөөр эдгээр үйлдвэрүүд хувьд шилжин ажиллаж байна.

## 1.Аж үйлдвэр



Дундговь аймгийн аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 2018 онд /оны үнээр/ нийт 9330.3 сая төгрөг болсон байна. Энэ нь өмнөх онтой харьцуулахад 15.2 хувиар буюу 1232.5 сая төгрөгөөр өссөн үзүүлэлт юм. Дээрх өсөлтөнд уул уурхай олборлох аж үйлдвэр 19.6 хувиар, цахилгаан дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж үйлдвэрлэл 14.9 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна. Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, өсөлтийн хувийг Зураг.1-д харууллаа.

Зураг.1



Мөн тухайн онд өмнөх онтой харьцуулбал боловсруулах аж үйлдвэрийн салбар 4.7 хувиар өссөн байна.

Хүснэгт-1. Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлт/дэд салбараар, сая.төг/


	2000	2005	2010	2015	2016	2017	2018	2018/ 2017 %
<b>Дунговь-Нийт дүн</b>	<b>1118.4</b>	<b>1643.7</b>	<b>3066.5</b>	<b>7542.6</b>	<b>7233.1</b>	<b>8097.8</b>	<b>9330.3</b>	<b>115.2</b>
<b>Уул уурхайн олборлох аж үйлдвэр</b>	<b>81.9</b>	<b>170.5</b>	<b>797.31</b>	<b>4033.5</b>	<b>2959.9</b>	<b>3049.5</b>	<b>3648.3</b>	<b>119.6</b>
Нүүрс	78.3	136.1	218.6	393.7	500.6	379.9	427.3	112.5
Гөлтгөнө	3.6	16	285.0	876	233.6	676.9	654.1	96.6
Жонш		18.4	293.7	2763.8	2225.7	1992.7	2566.9	128.8
<b>Боловсруулах аж үйлдвэр</b>	<b>688.7</b>	<b>922.1</b>	<b>801.06</b>	<b>1059.2</b>	<b>1152.9</b>	<b>1170.4</b>	<b>1225.8</b>	<b>104.7</b>
Хүнсний бүтээгдэхүүн, ундаа үйлдвэрлэл	618.7	706.2	636.4	653.6	836.7	879.6	944.0	107.3
Хуснэгт маягт үйлдвэрлэл	6.7	10.6	10.9	17.6	14.7	19.1	22.4	117.3
Боловсруулах бусад үйлдвэр	63.3	205.3	153.7	388	301.5	271.7	259.4	95.5
<b>Цахилгаан дулааны эрчим хүч үйлдвэрлэлт, усан хангамж</b>	<b>347.8</b>	<b>551.1</b>	<b>1468.1</b>	<b>2449.9</b>	<b>3120.3</b>	<b>3877.9</b>	<b>4456.2</b>	<b>114.9</b>
Цахилгаан, дулаан, уур үйлдвэрлэл	257.4	447.7	1322.7	1947.3	2605.4	3200.4	3773.3	117.9
Ус ариутгал ус хангамж	68.2	103.4	145.4	502.6	514.9	677.5	682.9	100.8
Цахилгаан	22.2	0						

2018 оны байдлаар аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийн 47.8 хувийг цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж, 39.1 хувийг уул уурхайн олборлох аж үйлдвэр, 13.1 хувийг боловсруулах аж үйлдвэр тус тус эзэлж байна. Үйлдвэрийн салбарын бүтцийн өөрчлөлтийг сүүлийн 3 жилээр 8 дэд салбаруудаар харууллаа. /Зураг 2-т/

2018 оны салбарын бүтцийг өмнөх онтой харьцуулбал боловсруулах аж үйлдвэрийн салбар 13 хувь болж 1 пунктээр буурч уул уурхай олборлох салбар 39 хувь болж өмнөх онтой харьцуулбал 1 пунктээр өссөн байна.

Зураг.2

### Аж үйлдвэрийн салбарын бүтэц хувиар



## 1.1 Уул уурхай олборлох аж үйлдвэр

2019 оны 1 сарын 1-ны байдлаар Дундговь аймгийн нутаг дэвсгэрт ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл 13 сумын нутагт 98, хайгуулын тусгай зөвшөөрөл 12 сумын нутагт 115, нийт 213 тусгай зөвшөөрөл байгаа бөгөөд эдгээрийн нийт талбайн хэмжээ 783 мянган га буюу нийт нутаг дэвсгэрийн 10.5 хувийг эзэлж байна.


Хүснэгт-2.Ашиглалт хайгуулын зөвшөөрөл олгосон байдал /сумаар/

Сумын нэр	Ашиглалтын тусгай зөвшөөрөл		Хайгуулын тусгай зөвшөөрөл		Бүгд	Талбайн хэмжээ Мян.га	Газар нутгийн хэдэн хувийг эзлэх
	тоо	Талбай	тоо	Талбай			
		Мян.га		Мян.га			
1.Дэлгэрцогт					0	0	0.00
2.Дэрэн			3	6.3	3	6.3	1.73
3.Говь-Угтаал	11	5.1	3	3.9	14	9	3.31
4.Цагаандэлгэр	3	4.4	6	11	9	15.4	4.44
5.Баянжаргалан	29	22.2	11	24.2	40	46.4	14.50
6.Өндөршил	7	30.7	20	142	27	172.7	35.45
7.Гурвансайхан	13	49	13	62.7	26	111.7	20.44
8.Өлзийт	9	19	30	135.1	39	154.1	9.95
9.Хулд	4	4.3	20	126.3	24	130.6	21.44
10.Луус	2	0.2	10	46.7	12	46.9	14.82
11.Дэлгэрхангай	19	8.3	11	55.4	30	63.7	10.24
12.Сайхан-Овоо	1	1.4			1	1.4	0.34
13.Эрдэнэдалай	6	5.8	6	12.5	12	18.3	2.49
14.Сайнцагаан	6	5.3			6	5.3	1.58
15.Адаацаг	3	0.2	1	1	4	1.2	0.36
<b>Дүн/давхардсан тоогоор/</b>	<b>113</b>	<b>155.9</b>	<b>134</b>	<b>627.1</b>	<b>247</b>	<b>783.0</b>	10.5
<b>Давхардаагүй тоогоор</b>	<b>98</b>	<b>155.9</b>	<b>115</b>	<b>627.1</b>	<b>213</b>	<b>783.0</b>	10.5

Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 2018 онд 3648.4 сая төгрөг болж өмнөх онтой харьцуулахад 19.6 хувиар буюу 598.9 сая төгрөгөөр өссөн байна. /Зураг.3/

Зураг.3


Уул уурхайн олборлох аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт /сая төг/



Гол нэр төрлийн бүтээгдэхүүнүүдийг өмнөх онтой харьцуулахад гөлтгөнө биет хэмжээгээр 32 хувиар, мөнгөн дүнгээр 3.4 хувиар буурсан бол нүүрс биет хэмжээгээр 2 хувиар буурч, мөнгөн дүнгээр 12.5 хувиар өссөн, жонш олборлолт биет хэмжээгээр 15.5 хувиар буурч, мөнгөн дүнгээр 28.8 хувиар өссөн байна./Зураг.4,Хүснэгт.3/

Зураг.4

Уул уурхайн гол нэр төрлийн бүтээгдэхүүний өсөлт, бууралт /биет хэмжээгээр/



Хүснэгт-3.Уул уурхайн гол нэр төрлийн бүтээгдэхүүн

Нэр төрөл	Хэмжих нэгж	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2018 /2017%
Хүрэн нүүрс	мян.тн	31.5	14.9	20.3	19	16	16.6	17.6	18.3	15.3	15	98.0
Жонш	мян.тн	14.9	17.3	30.8	16.4	13.5	30	32.6	26.8	11.6	9.8	84.5
Гөлтгөнө	мян.тн	1.5	3	0	0	0	0	12.7	7.3	38.1	25.9	68.0

2018 онд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөс орон нутгийн төсөвт 792.5 сая төгрөг, усны төлбөрөөс 57.9 сая.төгрөг, газрын төлбөрөөс 259.2 сая.төгрөгийн орлого орсон байна.

Хүснэгт-4. Ашигт малтмалын тусгай зөвшөөрлөөс төсөвт орсон төлбөр

№	Нэр төрөл	Хэмжих нэгж	2013	2014	2015	2016	2017	2018
1	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	Сая.төг	814.3	876.9	784.1	4579.7	1465.4	792.5
2	Газрын төлбөр	Сая.төг	120	131	149	160.5	128.8	259.2
3	Усны төлбөр	Сая.төг	27.1	25.8	34.1	29.9	22.8	57.9

## 1.2 Боловсруулах аж үйлдвэр

Боловсруулах аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2018 онд 1225.8 сая төгрөг болж, өмнөх онтой харьцуулахад 4.7 хувиар өссөн байна. Тус салбарын энэхүү өсөлтөнд хүнсний бүтээгдэхүүн, ундаа үйлдвэрлэл өмнөх онтой харьцуулбал 7.3 хувиар, хүснэгт, маягт үйлдвэрлэл 17.5 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна. Харин боловсруулах үйлдвэрийн бусад үйлдвэрлэл 4.5 хувь буюу 12.3 сая.төгрөгөөр буурсан байна. / Зураг.5 /

Зураг.5



Гол нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг өмнөх онтой харьцуулахад хүснэгт маягт, талх, бялуу, архи, ундаа, хиам, тараг, ааруул, модон эдлэл үйлдвэрлэл өссөн бол нарийн боов, чихэр, цэвэр ус, гоймон, хэрчсэн гурил, вакум цонх хаалга, оёдол эсгүүр үйлдвэрлэл буурсан үзүүлэлттэй байна. Боловсруулах аж үйлдвэрийн гол нэр төрлийн бүтээгдэхүүнүүдийг сүүлийн 10 жилээр өсөлт бууралтыг хүснэгт 5-д харууллаа.

**Хүснэгт-5. Боловсруулах аж үйлдвэрийн гол нэр төрлийн бүтээгдэхүүн**

Гол нэр төрлийн бүтээгдэхүүн	Хэмжих нэгж	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2018/2017
Хүснэгт маягт	м,х,д,х	167.4	156.8	149.7	116.6	210.7	197.1	250.5	210.1	272.9	320.1	1.17
Талх	тн	89.1	116.6	100.6	109.7	75.3	89.5	99.5	115.2	116.8	126.2	1.08
Нарийн боов	тн	89	174.5	107.6	105.4	102.4	93.1	98.7	112.8	115.4	111.5	0.97
Чихэр	тн	0	0	0	0	1.5	1.8	2.5	2.5	3.4	3.3	0.97
Бялуу	тн	0	0	0	0	0	0.9	2.3	3.7	1.1	2.1	1.91
Архи	мян.л	65.3	70	52.8	44.3	27	18.5	17.1	27.1	27.9	29.3	1.05
Ундаа	мян.л	9	6.4	7.5	3.4	4.3	1.6	1.4	2	1.7	8.6	5.06
Цэвэр ус	мян.л	6.1	3.2	5.7	2.1	5	5.7	8.4	7	15.4	24.1	1.56
Гоймон	тн	0	4.9	9.2	20.1	28.8	23.8	20.6	20.2	20.4	16.6	0.81
Хэрчсэн гурил	тн	0	0	0	0	5	9.4	8.8	9.1	9.6	4.2	0.44
Хиамны зүйл	тн	4.8	4.5	5.1	2.6	4	1.7	1.5	0.4	0.4	0.8	2.00
Тараг	мян.л	2.9	8	5.6	7.6	11.7	18.2	9.3	12.9	5.4	6	1.11
Хоормог	мян.л	2.1	1.2	2.5	2.7	1.1	0.6	0.2	0.7	0.7	0.5	0.71
Ааруул	тн	2.4	1.3	1.2	2.4	0.7	1.5	1.6	1.1	0.9	3.3	3.67
Вакум хаалга,цонх	м <sup>2</sup>	775	800	610	550	493	812	331	500	220	207	0.94
Блок	мян.ш	16	21.8	11.6	8.5	45.6	78.6	28.7	41.6	20	7.2	0.36
Оёдол эсгүүр	мян.төг	13170	11916	13059	24379	281756	194144	76204	92103	67765	54427	0.80
Модон эдлэл үйлдвэрлэл	мян.төг	38421	36205	47860	89201	120714	144975	214948	208273	102643	151560	1.48

Боловсруулах аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэлийг бүтцээр нь авч үзвэл хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл 75.2 хувь, хэвлэх үйлдвэр 1.6 хувь, боловсруулах үйлдвэрийн бусад салбарын үйлдвэрлэл 23.2 хувийг тус тус эзэлж байна. Энэ нь өнгөрсөн онтой харьцуулахад хүнсний үйлдвэрлэлийн эзлэх хувь 2.5 пунктээр, хүснэгт маягт үйлдвэрлэлийн эзлэх хувь 0.3 пунктээр өссөн үзүүлэлт бол харин боловсруулах үйлдвэрлэлийн бусад салбарын эзлэх хувь 2.9 пунктээр буурсан үзүүлэлттэй байна.

Аймгийн боловсруулах бусад салбарын үйлдвэрлэлийн дийлэнх хувийг жижиг дунд бизнес эрхлэгчид бүрдүүлж байна. Монгол улсын төрөөс жижиг дунд үйлдвэрлэгчдийг дэмжих зорилгоор тогтмол хэрэгжүүлдэг сангуудын мэдээллийг харвал “Жижиг дунд үйлдвэрийг дэмжих сан” сүүлийн 3 жил буюу 2016, 2017, 2018 онд тус аймагт зээл олгогдоогүй бөгөөд Жижиг дунд үйлдвэрийн бодлогын сангаас 2017 онд 1 ААН 1 төсөл, 2018 онд 2 ААН 2 төсөлд нийт 900 сая төгрөгийн зээл авсан байна. 2019 онд тус аймагт “Жижиг дунд үйлдвэрийг дэмжих сан” –аас 1 тэрбум төгрөг хуваарилагдаад байна.

Жижиг дунд үйлдвэрийг дэмжих зорилготой Сум хөгжүүлэх сан сүүлийн жилүүдэд тогтмол зээл олгосон байна. Сум хөгжүүлэх сан 2018 онд аймгийн хэмжээнд 63 төсөлд 713.2 сая төгрөгийн зээлийг олгосон бөгөөд үүний үр дүнд 48 ажлын байр хадгалагдаж, шинээр 79 ажлын байр нэмэгджээ. Зураг.6

Хүснэгт-6. Сум хөгжүүлэх сангийн зээл олголт, сумаар

Сум	2017 он				2018 он			
	төслийн тоо	зээлийн хэмжээ /МЯН.ТӨГ/	Шинэ ажлын байр	Хадгалагдсан ажлын байр	төслийн тоо	зээлийн хэмжээ /МЯН.ТӨГ/	Шинэ ажлын байр	Хадгалагдсан ажлын байр
Сайнцагаан	26	555,600	77	41	20	318,200	30	26
Луус	11	72,830	11	-	1	20,000	-	1
Хулд	12	91,000	12	-	8	56,500	8	-
Дэлгэрхангай	4	32,000	4	-	-	-	-	-
Сайхан-Овоо	11	38,500	6	11	-	-	-	-
Эрдэнэдалай	-	-	-	-	15	127,000	18	14
Адаацаг	22	84,500	11	11	6	65,500	6	-
Дэлгэрцогт	10	69,350	10	-	4	40,000	3	1
Дэрэн	-	-	-	-	-	-	-	-
Цагаандэлгэр	-	-	-	-	-	-	-	-
Говь-Угтаал	19	112,200	11	8	-	-	-	-
Баянжаргалан	5	41,500	5	-	-	-	-	-
Өндөршил	6	51,000	4	2	1	10,000	-	1
Гурвансайхан	2	33,000	2	-	4	39,000	6	1
Өлзийт	3	16,100	3	3	4	37,000	8	4
Нийт	131	1,197,580	156	76	63	713,200	79	48

Зураг.6

Сум хөгжүүлэх сангийн зээл олголт



**1.3 Цахилгаан дулаан үйлдвэрлэл, усан хангамж**

Дундговь аймгийн төв болон 14 сум бүхэлдээ төвлөрсөн эрчим хүчний системд холбогдсон бөгөөд тус аймагт Багануур-Зүүн өмнөд бүсийн Цахилгаан Түгээх Сүлжээ ТӨХК-ийн Дундговь Цахилгаан Түгээх сүлжээ салбар ажиллаж байна. Дулаан хангамжийн хувьд аймгийн төв Сайнцагаан сумын аж ахуй нэгжүүд болон аймгийн айл өрхийн хэрэглэгчдэд Ган-Илч ХХК, Тэвшийн говь ХХК болон


Дундговь-Ус ОНӨУҮГ, Ариунболор ХХК-ууд дулаан үйлдвэрлэн түгээж байна. Мөн аймгийн нийт 14 сумаас 11 сум нь төвлөрсөн халаалтын системд холбогдоод байгаа бөгөөд үүнээс 6 суманд Ган-Илч ХХКомпани дулаанаар ханган ажиллаж байна.

Дундговь аймгийн төв болон 14 сумын нийт хүн амын цэвэр усны хэрэглээг газрын гүний усаар хангаж байна. Тус аймгийн усан хангамж болон цэвэр бохир усны хангамж ариутгалын салбарт Дундговь-Ус ОНӨҮГ дангаараа үйл ажиллагаагаа явуулж аймгийн иргэдийн эрэлт хэрэгцээг ханган ажиллаж байна. Дундговь –Ус ОНӨҮГ нь Дундговь аймгийн төв Сайнцагаан сумын хүн ам, албан газар, аж ахуй нэгжийг цэвэр усаар хангах, бохир усыг татан зайлуулж цэвэрлэн халдваргүйжүүлэх, нийтийн халуун усны ашиглалт, 2.1мв, 0.5 мв хүчин чадалтай нам даралтын зуухны ашиглалтыг хариуцаж дулаан үйлдвэрлэх түгээх үйлчилгээг холбогдох тусгай зөвшөөрлүүдийн дагуу хариуцан ажилладаг 100 хувийн орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар юм.

Цахилгаан дулаан үйлдвэрлэл, усан хангамжийн салбар 2018 онд 4456.1 сая төгрөгт хүрч өмнөх оноос 14.9 хувиар буюу 578.2 сая төгрөгөөр өссөн байна. /Зураг.7/

Зураг.7

### ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧ ҮЙЛДВЭРЛЭЛ,УСАН ХАНГАМЖ /САЯ ТӨГ/



Мөнгөн дүнгээр авч үзвэл өмнөх онтой харьцуулахад дулаан үйлдвэрлэл 3773.3 сая төгрөгт хүрч, 17.9 хувь буюу 573 сая төгрөгөөр, усан хангамж ариутгал 682.9 сая төгрөгт хүрч 0.8 хувиар буюу 5.4 сая төгрөгөөр тус тус өссөн байна. Салбарын гол нэр төлийн бүтээгдэхүүнийг биет хэмжээгээр өмнөх онтой харьцуулвал сувагжуулалт 8.2 хувиар өссөн бол дулааны эрчим хүч 9.9 хувиар, түгээсэн цэвэр ус 0.3 тус тус буурсан байна.

Хүснэгт-7. Цахилгаан дулаан үйлдвэрлэл, усан хангамжийн салбарын гол нэр төрлийн бүтээгдэхүүн


Үзүүлэлт	Хэмжих нэгж	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2018/ 2017
Цахилгаан дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж												
Дулааны эрчим хүч	мян.ккл	32.9	113.4	79.6	69.4	69.9	68.1	80.7	87.8	101.2	91.2	90.1
Түгээсэн цэвэр ус	мян.м <sup>3</sup>	50.7	40.9	70.9	58.7	80	76.4	100.3	89.1	122.3	121.9	99.7
Сувагжуулалт	мян.м <sup>3</sup>	28	26.8	41.2	37.7	44.8	49.8	66.9	67.7	78.3	84.7	108.2

## 2. Барилга



Дундговь аймгийн хэмжээнд 2018 онд 9515.0 сая төгрөгийн барилга угсралт их засварийн ажил хийгдэж, өнгөрсөн онтой харьцуулахад 18.9 хувиар өссөн байна. Энэ онд 8971.8 сая төгрөгийн барилга угсралтын ажил, 543.5 сая төгрөгийн их засварын ажил хийжээ. /Зураг.8./

Зураг.8



2018 онд 700.0 сая төгрөгийн орон сууцны барилга, 3330.5 сая төгрөгийн худалдаа үйлчилгээний зориулалттай барилга, 1350.0 сая төгрөгийн эмнэлгийн зориулалттай барилга, 85 сая төгрөгийн конторын зориулалттай барилга, 1254.2 сая төгрөгийн орон сууцны бус бусад барилга, 97.5 сая төгрөгийн эрчим хүчний зориулалттай барилга, 1509.9 сая төгрөгийн сургуулийн барилга, 629.0 сая төгрөгийн спорт биеийн тамирын зориулалттай барилга, 15.7 сая төгрөгийн далан суваг, шугамын ажил, 543.2 сая төгрөгийн орон сууцны бус их засварын ажил хийгдсэн байна.

Хүснэгт-8. Дундговь аймгийн барилга угсралт, их засварын ажлын бүтэц /сая.төг/

№	Барилгын төрөл	2014 он	2015 он	2016 он	2017 он	2018 он	2018/2017 хувь
1	Орон сууцны барилга	4110.3	557.7	1950.0	1620.0	700.0	43.2
2	Орон сууцны барилга, гараантай	3032.0	400.0	0.0		0.0	-
3	Худалдаа, үйлчилгээний	768.4	1436.7	4033.2	1462.3	3330.5	227.8
4	Эмнэлэг	376.0	861.0	179.3	300.0	1350.0	450.0
5	Цэцэрлэг	2122.8	258.5	0.0	-	-	-
6	Сургууль	2260.6	4818.0	130.0	-	1509.9	-
7	Соёлын	1140.0	2280.7	599.5	-	-	-
8	Спорт, биеийн тамир	187.7	1562.5	0.0	-	629.0	-
9	Конторын	1117.1	809.5	1460.5	80.3	85.0	105.9
10	Орон сууцны бус бусад барилга	731.1	1259.2	376.6	459.7	1254.2	272.8
11	Эрчим хүчний	4503.8	128.7	195.0	44.9	97.5	217.3
12	Хатуу хучилттай авто зам	0.0	1655.7	413.9	820.7	0.0	0.0
13	Сайжруулсан хөрсөн зам	0.0	1655.7	95.0	-	-	-
14	Далан, суваг, шугам	2081.1	453.6	0.0	164.3	15.7	9.5
15	Бусад (бусад зам, талбайн ажил)	1219.7	1886.7	220.3	268.3	-	-
16	Орон сууцны барилгын их засвар	116.4	0.0	1350.4	169.0	0.0	0.0
17	Орон сууцны бус барилгын их засвар	1734.3	1022.2	0.0	2562.1	543.2	21.2
18	Инжежерийн барилга байгууламжийн их засвар	397.2	0.0	94.5	52.0	0.0	0.0
	Нийт	<b>25898.6</b>	<b>21046.3</b>	<b>11098.3</b>	<b>8003.6</b>	<b>9515.0</b>	<b>118.9</b>

2018 онд манай аймагт өрнөсөн томоохон бүтээн байгуулалтаас дурдвал аймгийн төвд Захын урд талд байрлах 16 айлын орон сууц, Бүрд зочид буудал зоогийн газар, Жаргалант худалдааны төвийн барилга зэрэг томоохон барилга баригдсан байна.

### 3.Тээвэр холбоо



**Тээвэр:** 2018 оны байдлаар зорчигч тээвэр 29.6 мянга болж өмнөх оноос 1 хувиар өсч, зорчигч эргэлт мөн 1 хувиар өсч 8140 мян.хүн.км болсон байна.


#### Хүснэгт-9. Зорчигч тээврийн мэдээ

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2009	2014	2015	2016	2017	2018	2018/2017
Зорчигч эргэлт	мян.хүн.км	13743	12530.6	5961.7	12004.8	8057.5	8140	101.0
Зорчигчид Орлого	мян.хүн мян.төг	24.9	30.2	18.8	43.6	29.3	29.6	101.0
		44449	53455.6	30757.2	32450.7	31601.5	34092.1	107.9

Зорчигч тээврийн орлого 34.1 сая төгрөг болж өмнөх оноос 7.9 хувиар буюу 2.5 сая төгрөгөөр өссөн байна. /Зураг.9/

Зураг.9

ЗОРЧИГЧ ТЭЭВРИЙН ОРЛОГО,МЯН.ТӨГ



**Холбоо:** Дундговь аймгийн хувьд Өлзийт, Дэлгэрхангай сумдаас бусад бүх сумд шилэн кабельд холбогдсон бөгөөд сумдууд шилэн кабель ашиглаж өндөр хурдаар интернэтэд холбогдож байна. Мөн 2018 онд тус аймгийн төвд Харилцаа холбооны салбарын тэргүүлэгч компаниудын нэг Юнител группын Юнивишн компани өрхийн интернэтийн холбоос, телевизийн суваг, суурин утас гурвыг нэгтгэсэн гурвалсан Юнивишн IPTV үйлчилгээг амжилттай нэвтрүүлсэн байна. Үүрэн телефоны сүлжээний хувьд юнител, мобиком бүх сумдад, скайтелын сүлжээ 11 сум /Цагаандэлгэр, Өлзийт сумдын сүлжээ ажиллахгүй байгаа/, жимобайл 14 суманд /Гурвансайханаас бусад/ сүлжээтэйгээс мобиком компани 10 суманд, Юнител компани өөрийн сүлжээтэй Дэлгэрхангай, Цагаандэлгэр сумаас бусад бүх сумдад 4 жи технологи нэвтрүүлж хэрэглэгчиддээ өндөр хурдны интернет ашиглах боломжийг хангаж өгсөн байна.

Хүснэгт-10. Үүрэн телефоны сүлжээ

Сумд	Мобиком	Скайтел	Юнител	Жи-Мобайл
Дэлгэрцогт	4жи	3жи,	4жи	3 жи
Дэрэн	4жи	3жи, 2жи	4жи	2жи
Говь-Угтаал	4жи	3жи, 2жи	4жи	3жи
Цагаандэлгэр	4жи		2жи	2жи
Баянжаргалан	4жи	3жи, 2жи	4жи	2жи
Өндөршил	3жи	3жи, 2жи	4жи	2жи
Гурвансайхан	4жи	3жи, 2жи	4жи	-
Өлзийт	2жи		4жи	3жи
Хулд	2жи	3жи,	4жи	3жи
Луус	2жи	3жи,	4жи	3жи
Дэлгэрхангай	2жи	-	2жи	3жи
Сайхан-овоо	4жи	-	4жи	3 жи
Эрдэнэдалай	4жи	3жи,	4жи	3 жи
Сайнцагаан	4жи	3жи, 2жи	4жи	3жи
Адаацаг	4жи	3жи,	4жи	2 жи

Холбооны салбарын мэдээгээр 2018 онд тарифын орлого 431.3 сая төгрөг болж өмнөх онтой харьцуулахад 0.6 хувиар өссөн байна. Интернет цэгээр үйлчлүүлэгчдийн тоо 1318 болж өмнөх онтой харьцуулахад 3.5 дахин буурсан бол суурин телефон цэгийн тоо 518 болж мөн 9.7 хувиар буурчээ.

Хүснэгт-11. Холбооны мэдээ

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2010	2013	2014	2015	2016	2017	2018	2018 /2017
Тарифын орлого	сая.төг	193	259.22	325.2	428.6	366.4	433.8	431.3	99.4
Үүнээс хүн амын	сая.төг	108.6	76.812	99.35	88.6	85.3	74	44.4	60.0
Суурин телефон цэг	тоо	796	695	686	647	640	518	468	90.3
Интернет цэгийн үйлчлүүлэгчдийн тоо	тоо	4830	10884	13573	9863	9329	4665	1318	28.3

#### 4.Бизнес регистрийн сан.

Статистикийн хэлтсийн бизнес регистрийн санд 2018 оны байдлаар аймгийн хэмжээнд нийт 1057 аж ахуй нэгж бүртгэлтэй байгаа нь өнгөрсөн оноос 9.5 хувиар өссөн үзүүлэлт байна. Үүнээс 138 төсөвт байгууллага, 158 төрийн бус байгууллага, 21 төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, 648 ААНБ байна. Нийт аж ахуй нэгжийг үйл ажиллагаа эрхлэлтийн байдлаар, сумаар хүснэгт-11-д харууллаа.

Хүснэгт-12. Бизнес регистрийн санд бүртгэлтэй нийт аж ахуй нэгж, үйл ажиллагаа эрхлэлтийн байдлаар, сумаар

Сумын нэр	Үйл ажиллагаа явуулж байгаа		Үйл ажиллагаа эхлээгүй байгаа		Үйл ажиллагаа түр зогсоосон		Үйл ажиллагаа бүрэн зогсоосон		Бусад		Нийт	
	2017	2018	2017	2018	2017	2018	2017	2018	2017	2018	2017	2018
Дэлгэрцогт	20	20	3	3	0	0	0	1	0	0	23	24
Дэрэн	15	16	4	3	1	1	2	2	0	0	22	22
Говь-Угтаал	18	18	2	3	3	3	0	0	0	0	23	24
Цагаандэлгэр	14	15	5	4	0	0	0	1	0	0	19	20
Баянжаргалан	19	22	7	11	1	2	1	1	0	0	28	36
Өндөршил	25	23	3	4	12	14	1	1	0	0	41	42
Гурвансайхан	22	22	0	8	5	7	1	1	0	0	28	38
Өлзийт	21	20	5	8	5	5	1	2	0	0	32	35
Хулд	28	30	4	5	6	9	1	1	0	0	39	45
Луус	19	18	2	9	0	1	0	0	0	0	21	28
Дэлгэрхангай	24	26	4	5	3	4	4	2	0	0	35	37
Сайхан-Овоо	30	31	1	1	4	3	0	0	1	1	36	36
Эрдэнэдалай	37	37	3	6	8	8	1	1	0	0	49	52
Сайнцагаан	324	338	100	112	96	110	14	22	1	1	535	583
Адаацаг	23	27	4	1	5	6	2	1	0	0	34	35
Нийт	639	663	147	183	149	173	28	36	2	2	965	1057

Нийт ААН-ийн 62.7 хувь нь буюу 663 ААНБайгууллага идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна. Бизнес регистрийн санд бүртгэлтэй нийт ААНБ болон үйл ажиллагаа идэвхтэй явуулж байгаа ААНБ-н тоог сүүлийн жилүүдээр графикт харууллаа. /Зураг.10/

Зураг.10

БИЗНЕС РЕГИСТРИЙН САНД БҮРТГЭЛТЭЙ ААНБ,  
ҮҮНЭЭС ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА ААНБ-ЫН  
ТОО




Үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгж, байгууллагыг салбараар авч үзвэл 33 хувь буюу 220 нь бөөний болон жижиглэн худалдааны чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байна. Дэлгэрэнгүйг Зураг 11-т харууллаа.




Зураг.12

ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН/ОНЫ ҮНЭЭР, ТЭРБУМ.ТӨГ/



Дундговь аймгийн ДНБ 2018 оны урьдчилсан гүйцэтгэлээр төвийн бүсийн ДНБ-ий 11 хувийг эзлэж байна./Зураг.13 /

Зураг.13



Аймгийн ДНБ-ийг бусад төвийн бүсийн аймгуудтай харьцуулан сүүлийн жилүүдээр хүснэгтэд харууллаа.

Хүснэгт-13. Төвийн бүсийн аймгуудын ДНБ, сая.төг

Төвийн бүсийн аймгууд	2013	2014	2015	2016	2017	2018*	2018/2017
Дорноговь	273119	308754.4	261319.1	272288.4	296014.8	349617.2	118.1
<b>Дундговь</b>	<b>179401</b>	<b>213115</b>	<b>237565.8</b>	<b>226072.5</b>	<b>258177</b>	<b>319543.6</b>	<b>123.8</b>
Өмнөговь	454724.4	335829.8	281273.5	404035.8	714470.2	597384.9	83.61
Сэлэнгэ	492578.3	586241.7	574519.5	555423	598216.1	680615.3	113.8
Төв	374514.9	474494.1	542576.3	510608.8	510446.5	594206.5	116.4
Дархан-Уул	305144	362087.7	367262.7	387260.4	409544.4	435751.1	106.4
Говьсүмбэр	57641.5	72860.8	83724.4	83354.9	83959.4	91702.8	109.2

2018 оны ДНБ-ий бүтцийг салбараар авч үзвэл ХАА-н салбар 61 хувь, тэр дундаа мал аж ахуйн салбар 60.8 хувийг аж үйлдвэрийн салбар 15 хувь, барилгын салбар 0.1 хувь үйлчилгээний салбар 24 хувийг тус тус эзэлж байна. ДНБ-ий бүтцийг эдийн засгийн салбараар дэлгэрэнгүй хүснэгт 14-т харууллаа.


Хүснэгт-14. Дундговь аймгийн ДНБ-ний бүтэц

Салбар	2013	2014	2015	2016	2017	2018*	Эзлэх %
ДНБ, зах зээлийн үнээр /сая.төг/	179401	213115	237565.8	226072.5	258177	319543.6	
<b>Хөдөө аж ахуй</b>	<b>108700.8</b>	<b>130102.3</b>	<b>142675.6</b>	<b>124658.5</b>	<b>146308.6</b>	<b>194903.7</b>	<b>61.0</b>
Газар тариалан	151	236	200.1	378.8	431.9	432.6	0.1
Мал аж ахуй	108549.7	129866.3	142475.5	124253.5	145876.7	194416.4	60.8
ХАА-н бусад	0	0	0	26.2	0	54.8	0.0
<b>Үйлдвэрлэл</b>	<b>21319.2</b>	<b>22001.2</b>	<b>28305.9</b>	<b>31922.3</b>	<b>37832.3</b>	<b>47813.1</b>	<b>15.0</b>
Уул уурхай, олборлох	867.5	1329.4	3296.1	2472.1	2018.5	2669.7	0.8
Боловсруулах	18251	18133.2	22584.8	26195.3	32818.9	42119.7	13.2
Цахилгаан, хий, уур хангамж; усан хангамж	1726.9	2055	2146.4	2992.6	2766.7	2730.7	0.9
<b>Барилга</b>	<b>473.7</b>	<b>483.6</b>	<b>278.7</b>	<b>262.4</b>	<b>228.2</b>	<b>292.9</b>	<b>0.1</b>
<b>Үйлчилгээ</b>	<b>49381.1</b>	<b>61011.6</b>	<b>66584.3</b>	<b>69491.7</b>	<b>74036.1</b>	<b>76826.8</b>	<b>24.0</b>
Худалдаа, зочид буудал, зоогийн газар	8051.5	8337.5	7633.5	7338.3	7911.6	9207.6	2.9
Тээвэр, мэдээлэл, холбоо	4466	5038.6	4925.7	4241	5367	5371.6	1.7
Санхүү, бизнесийн бусад үйл ажиллагаа	12137.5	14433.9	18053.1	19002.4	21008.1	20726.5	6.5
Бусад үйлчилгээ	24726.1	33201.6	35972	38910	39749.4	41521.1	13.0

Аймгийн 1 хүнд ногдох ДНБ 2018 онд 6856.9 мянган төгрөгт хүрсэн байгаа нь өмнөх оны үзүүлэлтээс 22 хувиар өссөн үзүүлэлт юм. Зурагт аймгийн нэг хүнд ноогдох ДНБ-ийг сүүлийн 10 жилээр харууллаа. /Зураг.14/

Зураг.14


### АЙМГИЙН НЭГ ХҮНД НОГДОХ ДНБ /МЯН.ТӨГ/



Нэг хүнд ногдох ДНБ 2018 онд улсын дундаж 10159.3 мянган төгрөг, Улаанбаатар хот 14933.9 мянган төгрөг байгаа бол Орхон аймгийн нэг хүнд ногдох ДНБ хамгийн өндөр буюу 17912.1 мянган төгрөг байна. Манай аймгийн хувьд 6856.9 мянган төгрөгт хүрсэн нь 21 аймгаас нэг хүнд ногдох ДНБ-ээрээ 5 дугаарт эрэмбэлэгдсэн үзүүлэлт юм. Зурагт нэг хүнд ноогдох ДНБ-ийг Улсын дундаж, Улаанбаатар хот болон 21 аймгуудаар зэрэгцүүлэн харууллаа. /Зураг-15/

Зураг.15

### Нэг хүнд ногдох ДНБ-2018 /оны үнээр, мян.төг/



2018\*- 2018 оны ДНБ-ийг урьдчилсан гүйцэтгэлээр тооцсон болно.

## Дүгнэлт

Дундговь аймгийн аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 2018 онд /оны үнээр/ нийт 9330.3 сая төгрөг болсон байна. Энэ нь өмнөх онтой харьцуулахад 15.2 хувиар буюу 1232.5 сая төгрөгөөр өссөн үзүүлэлт юм. Дээрх өсөлтөнд уул уурхай олборлох аж үйлдвэр 19.6 хувиар, цахилгаан дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж үйлдвэрлэл 14.9 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна. Мөн тухайн онд өмнөх онтой харьцуулбал боловсруулах аж үйлдвэрийн салбар 4.5 хувиар өссөн байна.

Дундговь аймгийн хэмжээнд 2018 онд 9515.0 сая төгрөгийн барилга угсралт их засварийн ажил хийгдэж, өнгөрсөн онтой харьцуулахад 18.9 хувиар өссөн байна. Энэ онд 8971.8 сая төгрөгийн барилга угсралтын ажил, 543.5 сая төгрөгийн их засварын ажил хийжээ.

2018 оны байдлаар зорчигч тээвэр 29.6 мянга болж өмнөх оноос 1 хувиар өсч, зорчигч эргэлт мөн 1 хувиар өсч 8140 мян.хүн.км болсон байна. Зорчигч тээврийн орлого 34.1 сая төгрөг болж өмнөх оноос 7.9 хувиар буюу 2.5 сая төгрөгөөр өссөн байна.

Холбооны салбарын мэдээгээр 2018 онд тарифын орлого 431.3 сая төгрөг болж өмнөх онтой харьцуулахад 0.6 хувиар өссөн байна. Интернэт цэгээр үйлчлүүлэгчдийн тоо 1318 болж өмнөх онтой харьцуулахад 3.5 дахин буурсан бол суурин телефон цэгийн тоо 518 болж мөн 9.7 хувиар буурчээ.

2018 оны аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүн оны үнээр урьдчилсан гүйцэтгэлээр 319.5 тэрбум төгрөг болж өмнөх онтой харьцуулахад 23.8 хувиар буюу 61.3 тэрбум төгрөгөөр өссөн байна. ДНБ-ий бүтцийг салбараар авч үзвэл ХАА-н салбар 61 хувь, тэр дундаа мал аж ахуйн салбар 60.8 хувийг аж үйлдвэрийн салбар 15 хувь, үйлчилгээний салбар 24 хувийг тус тус эзэлж байна.

Аймгийн 1 хүнд ногдох ДНБ 2018 онд 6856.9 мянган төгрөгт хүрч, өмнөх оны үзүүлэлтээс 22 хувиар өссөн байна. Мөн энэ нь 21 аймгийн хэмжээнд авч үзвэл 5 дугаарт эрэмбэлэгдсэн үзүүлэлт юм.

Ашигласан ном материал

1. Монгол улсын статистикийн эмхэтгэл 2013-2017
2. Аймгийн нийгэм эдийн засгийн танинцуулга 2013-2018
3. Дундговь аймгийн товч түүх 1991 он
4. Аймгийн БР сан 2012-2018
5. [www.nso.mn](http://www.nso.mn)
6. [www.1212.mn](http://www.1212.mn)

Хамтран ажилласан

Хүнс хөдөө аж ахуйн газрын жижиг дунд үйлдвэрлэл хариуцсан мэргэжилтэн  
Ж.Мөнхбаяр

Хөгжлийн бодлогын хэлтсийн уул уурхай хариуцсан мэргэжилтэн П.Очирбат

ТАНИЛЦУУЛГА БЭЛТГЭСЭН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН: Т.БЯМБАСҮРЭН

УТАС: 70593715, 88593456

ФАКС: 70593715,

И-МЭЙЛ: [Dundgovi@nso.mn](mailto:Dundgovi@nso.mn), [Byambasuren@nso.mn](mailto:Byambasuren@nso.mn)

ХАЯГ: ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР 319,320 ТООТ  
ХЯНАСАН СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН ДАРГА: Б.ЭНХТУЯА

2019 ОНЫ 06 САРЫН 25